



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2018

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ¹**

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно”, 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална” гэжээ.

Түүнчлэн 5 дахь хэсэгт “Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно” гэж заасан. Тухайлбал, Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолоор баталсан “ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Тав дахь хэсгийн 5.3.12-д Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах тухай зорилт тусгагдсан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 161-д “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх талаар заасан.

Энэхүү хуулийн төслийг боловсруулахаар одоо хүчин төгөлдөр мөрдөж буй “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу уг судалгааг хийв.

Судалгааны зорилго нь хүчин төгөлдөр үйлчилж буй “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай” хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг үр дагаварыг тогтоох замаар цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдсэн.

ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /цаашид “ГИЭЗБТХ” гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын /цаашид “аргачлал” гэх/ дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар гүйцэтгэсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажлууд хийгдэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

¹ Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал удирдан, эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Ц.Оюунчимэг нар хамтран гүйцэтгэв.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Аргачлалын 3.2.2-т “хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалд нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг бүрэн хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол үнэлгээ хийх нөхцөл байдал үүссэн гэж үзнэ” хэмээн заасан байдаг.

ГИЭЗБТХ-тай холбоотой мэдээлэл цуглуулж, тэдгээрт дүн шинжилгээ хийх үе шатанд аргачлалын 3.2.2-т заасан нөхцөл байдал үүссэн байж болзошгүй байдал ажиглагдсан. Тодруулбал:

- Хуулийн зарим зохицуулалт бодит байдалд нийцээгүй;
- Нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрогдсон;
- Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээ онлайн хэлбэрт бүрэн шилжээгүй;
- Гадаадын иргэний эрх зөрчигдөх явдал ихсэж байгаа зэрэг шалтгаан нөхцөлийн улмаас хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгарсан гэж үзэн энэхүү судалгааг хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл /эерэг болон сөрөг/ үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа бөгөөд эдгээрийг хэр оновчтой сонгохоос судалгааны чанар ихээхэн хамаардаг. Иймд виз, бүртгэлийн журам зөрчигсдийг албадан гаргах арга хэмжээ авч буй байдлаас үүдэн ГИЭЗБТХ-ийн дор дурдсан хэм, хэмжээ /цаашид “үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалт гэх”/-г үнэлгээний хүрээнд хамруулахаар тодорхойлсон.

37 дугаар зүйл.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах
37.1.3. түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Үнэлгээний хүрээнд хамаарах хэм хэмжээг тодорхойлсны дараа аргачлалын 3.4-т заасан зургаан шалгуур үзүүлэлтээс аль нэгийг буюу хэд хэдийг сонгон, уг шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журамтай.

Энэ дагуу аргачлалын 3.4.5-д заасан практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийг сонгон, энэхүү үнэлгээг хийсэн ба уг шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох;

Тухайн хуульд үнэлгээ хийхдээ аргачлалын 3.5.3-т заасан дөрвөн харьцуулах хэлбэрээс аль тохиромжтойг нь сонгох журамтай. Энэ дагуу аргачлалын 3.5.3.4-д заасан харьцуулах хэлбэрийг сонгосон ба энэ нь тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ, өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт), хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан гаргасан судалгааг үнэлгээ хийхэд ашиглах хэлбэр юм.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалт тус бүр дээр “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэсэн асуулт тавьж үнэлгээг хийсэн.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсон ба үүнээс дараах хоёр аргыг сонгов. Үүнд:

1/ байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;

2/ холбогдох субъектээс судалгаа авах.

Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах: ГИЭЗБТХ-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх зорилгоор эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, уг судалгаатай холбоотой мэргэжлийн ном, товхимол, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, судалгааны тайлан, статистик мэдээлэл зэргийг цуглуулсан, үнэлгээ хийхэд ашигласан.

Холбогдох субъектээс судалгаа авах: Уг хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаардаг байгууллагын төлөөлөөс² ярилцлагын аргыг ашиглан нэмэлт мэдээлэл авсан. Мөн ГИЭЗБТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах нээлттэй хэлэлцүүлэг³-т оролцсон эрдэмтэн, судлаачид, холбогдох байгууллагын төлөөлөгч, судалгаа шинжилгээ хийдэг байгууллагын санал, дүгнэлтийг үнэлгээ хийхэд ашигласан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд мэдээлэл цуглуулах аргын дагуу бэлэн байгаа мэдээлэл, холбогдох субъектээс судалгаа аван дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ.

2.1.Бэлэн байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх.

Бэлэн байгаа мэдээлэл нь ГИЭЗБТХ-ийн холбогдолтой эрх бүхий байгууллагаас гаргасан мэргэжлийн ном, товхимол, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл (веб сайт болон бусад бүх төрлөөр нийтэлсэн мэдээлэл), судалгааны тайлан, статистик мэдээлэл, эрх зүйн актуудыг цуглуулсан. Цуглуулсан мэдээллээс цухас дурдвал:

Монгол Улс 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар хүн амын тоо 3.119.935 байгаа бөгөөд хүн амын 3 хувь хүртэл буюу 93600 гадаадын иргэн тус улсад оршин суух боломжтой. Харин 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар ГИХГ-т бүртгэлтэй 117 орны 25003 гадаадын иргэн оршин сууж байгаа нь МУ-ын хүн амын 0.8 хувьтай тэнцэж байна.⁴

Манай улсад гадаадын иргэдтэй холбоотой харилцааг дараах эрх зүйн акт⁵-аар зохицуулдаг байна.

- Монгол Улсын олон улсын гэрээ 27;
- Монгол Улсын хууль 193;
- Улсын Их Хурлын тогтоол 47;
- Засгийн газрын тогтоол 289;
- Ерөнхийлөгчийн зарлиг 7;
- Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 29;
- Улсын дээд шүүхийн тогтоол 12;
- Сайдын тушаал 27;
- Засгийн газрын агентлагийн даргын тушаал 6;
- УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр 1;
- Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэр 2.

² Гадаадын иргэн, харьяатын газрын дэд дарга Д.Түвшинтөр, Гадаадын иргэн, харьяатын газрын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Ч.Тулгацоодол, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Ганбат нартай хуулийн хэрэгжилтийн талаар 2018.11.14-ний өдөр уулзан мэдээлэл авсан.

³ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нээлттэй хэлэлцүүлэг, <http://www.immigration.gov.mn/blog/post/gadaadyn-irgenij-erh-zjn-bajdlyn-tuhaj-huuld-nemelt-rchllt-oruulah-tuhaj-neelttej-helelclee>. сүүлд үзсэн 2018.11.17.

⁴ Гадаадын иргэний шилжилт, хөдөлгөөний чиг хандлага, анхаарах асуудал: олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2017 он. 7 дахь тал.

⁵ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://www.legalinfo.mn/advanced-search> сүүлд үзсэн 2018.12.07.

Гадаадын иргэдтэй холбоотой дээрх үйлчилж буй эрх зүйн актаас одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж хоорондоо давхардсан, зөрчилдсөн, хийдсэн хууль хоорондын уялдаа холбоо хангалтгүй, хүчин төгөлдөр бус зохицуулалт нэлээдгүй байгаа төдийгүй гадаадын иргэний зээл, тусламж, хөрөнгө оруулалт оруулах явцад үүсэх эрх зүйн байдлын талаарх зохицуулалт болон бусад гадаадын иргэдийн эрх зүйн байдалтай хэрхэн уялдаж, аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй нь ойлгомжгүй (цахим орчинд илүүтэй ажиглагдаж байна), виз бүртгэлтэй холбоотой цахим орчин дахь эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа (төрийн захиргааны байгууллагын нягт холбоо, цагдаа, тагнуулын байгууллагатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох) зэрэг олон асуудал байна.

Судалгааны багийн зүгээс судалгааг гүйцэтгэх цаг хугацаа, хүний нөөцийн боломждоо тулгуурлан дээрх бүхий л асуудлыг бус үнэлгээний хүрээнд тодорхойлсон асуудлын хүрээнд үнэлэх юм.

2.2. Холбогдох субъектээс судалгаа авах

ГИЭЗБТХ-ийн үйлчлэлийн хүрээнд хамаардаг байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөллөөс ярилцлагын аргыг ашиглан нэмэлт мэдээлэл цуглуулахдаа Гадаадын иргэн, харьяатын газрын дэд дарга, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нартай уулзсанаас гадна Гадаадын иргэн, харьяатын газраас аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн төлөөллийн оролцоотой зохион байгуулсан хэлэлцүүлэгээс холбогдох мэдээлэл авсан.

Энэхүү мэдээллээс үнэлгээний хүрээнд хамаарах хэсгийг түүвэрлэн авснаас гадна хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад зайлшгүй хэрэг болох асуудлыг дараах байдлаар товч дурдлаа.⁶

1. ГИЭЗБТХ-ийн 5.1.4, 5.1.5, 5.1.6, дэх заалтад “түр ирэгч”, “хувийн хэргээр оршин суугч”, “албан хэргээр оршин суугч”-ийн ялгааг тодорхой болгох. Тухайлбал, МУ-д 90 хүртэл хоногийн хугацаагаар зорчигч “Түр ирэгч” байдаг бол 1 сарын хугацаатай ажиллаад, 1 сарын хугацаагаар визээ сунгаад зөвлөгөө заавар өгөөд гараад явдаг, тоног төхөөрөмж оруулж ирдэг гэх зэрэг улирлын шинж чанартай хөдөлмөр эрхлэгч байдаг үүнийг “албан хэргээр оршин суугч” гэж үзэж байна. ОУ-ын байгууллагын шугамаар 2 сарын хугацаатай орж ирсэн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг иргэнийг “албан хэргээр оршин суугч” гэж үзэж байгаа тул хугацаа болоод тодорхойлолтод анхаарах;

2. ГИЭЗБТХ-ийн 7.4.5 дахь заалтад “паспорт болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон оршин суух үнэмлэхийг биедээ авч явах” гэж заасан нь паспорт болон оршин суух үнэмлэх хоёрыг зэрэг биедээ авч явах болдог. Энэ нь паспорт хаях, гээх, урагдах эрсдэл гардаг төдийгүй эргээд гадаадын иргэндээ маш хүндрэлтэй байдал үүсгэдэг. Иймд олон улсын жишгээр зөвхөн үнэмлэх биедээ авч явах нь эрсдэл багатай байх тул энэ заалтыг өөрчлөх; (хуучин паспорт дээр тэмдэг тавьж явдаг байсныг өөрчлөн үнэмлэх болгосон)

3. ГИЭЗБТХ-ийн 11.5 дахь хэсэгт “виз нь орох, гарах-орох ...нэг хоёр олон удаагийн төрөлтэй байна” гэж заасан “оршин суух карттай бол” гарах орох виз авахыг шаардахгүй байх тухай олон улсын гэрээгээр заасан байдаг тул виз 180 хоногоос дээш хугацаагаар олгосон оршин суух үнэмлэхтэй бол гарах, орох виз шаардахгүй байхаар зохицуулах;

4. ГИЭЗБТХ-ийн 18.1 дэх хэсэгт “нэг удаагийн орох виз нь гадаадын иргэн МУ-ын хилээр нэвтрэх хүртэл 90 хоногийн хугацаанд хүчинтэй байна.” гэж заасан нь 4 сараас эхлэн аялах визээ авч материалаа бүрдүүлж 6 сараас эхлэн улс орнуудаар дамжин манайд ирэхэд визийн хугацаа дууссан байдаг тул 180 хоног болгох; (Тухайн

⁶ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нээлттэй хэлэлцүүлэг. ГИХГ-ын Эрх зүй, гадаад харилцааны ахлах мэргэжилтэн Г.Ганбатын илтгэлээс, /2018.11.23/

иргэн манай улсад ирсэн даруйдаа дахин виз авах хүндрэл, *чирэгдэл* үүсэхгүй байх боломжтой болох юм.)

5. ГИЭЗБТХ-ийн 22.1.1 дэх хэсэгт “16 насанд хүрээгүй эрх зүйн чадамжгүй гадаадын иргэнийг Монгол Улсад орохыг үл зөвшөөрнө” гэж заасан байдаг. Үүнийг 18 насанд хүргэх саналтай байна. 16 настай иргэн “сурах” болон бусад байдлаар нэвтрэх эрх олж авсан хэдий ч бие даан амьдрах нөхцөл боломж манай улсад хангалттай бүрдээгүй байх тул Олон улсын жишгийг даган 18 насанд хүрсэн тохиолдолд дангаар нэвтрэх эрхийг олгож байх;

6. ГИЭЗБТХ-ийн 22.1.2 дахь заалтад “Монгол Улсад ял шийтгүүлсний дараа тус улсаас гарсан бөгөөд ялгүйд тооцох хугацаа дуусаагүй бол” гэж заасан нь шинэчилсэн Эрүүгийн хуулиар ялгүйд тооцох хугацаа гэдэг ойлголт байхгүй болсон. Иймд хуулийн заалттай нийцүүлэн өөрчлөх;

7. ГИЭЗБТХ-ийн 24.1 дэх хэсэгт “Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ” гэж заасан нь Зөрчлийн тухай хуулиар өндөр торгууль төлөх, олон шат дамжлагатай бүртгэл хийгддэг. Ажлын 7 хоног гэж хатуу заалгүй 30 хоног гэж өөрчлөх;

8. Визийн ангилал, бүртгэлийн дугаар олгох асуудалд нэмж тусгах шаардлагатай асуудал үүсэж байна. Тухайлбал, визийн ангиллыг багасгасан нь жолоочийг аль ангилалд хамааруулах нь ойлгомжгүй болсон. Бүртгэлийн дугаарыг төрийн байгууллагууд тус бүр өөр байдлаар бүртгэж байгааг нэг болгох гэх мэт.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЕ ШАТ

ГИЭЗБТХ-тай холбоотой мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх явцад уг хуулийн зарим нэр томъёо цаг үеэсээ илт хоцорч, практикт зөрүүтэй байдал үүсэн, хууль хэрэгжүүлэх, оролцогч байгууллага тус бүрийн чиг үүрэг, эрх хэмжээг хуулиар тодорхой тусгаагүйгээс гадаадын иргэнийг албадан гаргах явдал ихсэж виз, бүртгэлийн асуудалд хүндрэл үүссэн гэж үзэн уг хуулийн холбогдох хэм, хэмжээ /37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалт/-г үнэлгээний хүрээнд хамруулахаар тодорхойлсон тухай тайлангийн төлөвлөх хэсэгт дурдсан.

3.1. Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

37 дугаар зүйл. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах
37.1.3. түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;

Судалгааны хүрээнд “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах” түүний дотор “түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн” тухай зохицуулалтыг сонгон Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр үнэлэхдээ хэрэгжиж байгаа эерэг, сөрөг үр дагаврыг тогтоон дүгнэлт, саналыг боловсруулсан. Ингэхдээ ГИЭЗБТХ-ийн зүйлийн нэртэй уялдуулан эхэнд нь албадан гаргах асуудлыг, түүний дараа виз, бүртгэлийн асуудалд үнэлгээ хийсэн болно.

3.1.1. Хэрэгжиж байгаа эерэг үр дагавар

Албадан гаргах. 1993 оны ГИЭЗБТХ-аар албадан гаргах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн хэрэгжүүлэхээр хуульчилж байсан. Харин 2010 оны ГИЭЗБТХ-ийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гадаадын иргэнийг МУ-аас албадан гаргах тухай шийдвэрийг гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын дарга гаргана.” гэснийг Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталгаажуулан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-д заасан зөрчил илрүүлсэн хяналтын улсын байцаагч нь тухайн гадаадын иргэний талаар хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт үйлдэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргад танилцуулна” гэснээр албадан гаргах ажиллагаа явагддаг байна.

ГИХГ нь ГИЭЗБТХ-ийн 37 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу албадан гаргах тухай шийдвэрийг хил хамгаалах болон цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх үүрэг хүлээдэг бол цагдаагийн байгууллага нь шаардлагатай тохиолдолд албадан гаргах гадаадын иргэнийг хилийн боомт хүртэл хуяглан хүргэх ажлыг зохион байгуулах, гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааг хэрэгжүүлэх явцад нисэх онгоцны болон галт тэрэгний буудалд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн хүч хэрэгслээр хамгаалалт зохион байгуулах, автомашинаар хүргэх үед зам тээврийн осол гарахаас сэргийлж, шаардлагатай тохиолдолд хамгаалалт хийх үүрэг хүлээдэг.

Харин хил хамгаалах байгууллага нь албадан гаргаж байгаа гадаадын иргэний талаар ОХУ, БНХАУ-ын хилийн шалган нэвтрүүлэх байгууллагад урьдчилан мэдэгдэж, хамтран ажиллах, албадан гаргаж байгаа гадаадын иргэнийг МУ-аас гарах үед хилээр нэн даруй нэвтрүүлэх ажиллагааг зохион байгуулах, албадан гаргах гадаадын иргэнийг шаардлагатай үед хилийн боомтод байрлуулах, хамгаалах, хоол, хүнсээр хангах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээ авах, албадан гаргах шийдвэрт заасан МУ-д дахин оруулахгүй байх хугацаанд гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэхгүй байх үүрэгтэй байдаг.

ШИГТГЭЭ


УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “Гишүүдэд мэдээлэл өгмөөр байна. Хилийн шалган нэвтрүүлэх чиг үүрэг Гадаадын иргэн, харьяатын байгууллагад очсоноор олон улсын стандартад нийцсэн юм. Гадаадын иргэд манай хилээр нэвтрэхдээ цэргийн хувцастай хүмүүст паспортаа шалгуулдаг байхад цэргийн дэглэмт улсад ирж байна гэсэн ойлголт төрдөг байсан. Үүнийг өөрчилсөн байсан. Түүнээс гадна мэдээлэл сайжирч, хяналт чангарснаар визийн хугацаа хэтэрсэн хүмүүсийг албадан гаргах ажиллагаа маш их идэвхжсэн. 1990 оноос хойш 10 мянга гаруй гадаадын иргэнийг албадан гаргасны 6000 гаруй нь сүүлийн гурван жилийн дотор байсан. Хилийн цэргээс шилжиж ирсэн 400 гаруй албан хаагч иргэний харьяат дээр ирсэн 4 өмнөх ажлаа л хийж байсан. Харин 4 сургалтад хамрагдаж, ажил нь сайжирсан” гэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн “2007-2012 онд намайг энэ байгууллагыг даргалж байхад нийт 9761 хүн гарсан байдаг. Үүнээс өмнө бол 10-20 орчим, зарим жилд 2 ч хүн гаргасан тохиолдол байсан. 2012-2016 онд 6700 хүн албадан гаргасан. Энэ нь Гадаадын иргэн, харьяатын байгууллагын статусыг дээшлүүлж, албадан гаргах шийдвэрийг бие даан гаргадаг болсонтой холбоотой” гэсэн юм.

УИХ, Хилийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс⁷. 2016 оны 12 сар

Монгол Улсаас гарч явах сануулга авсан гадаадын иргэн 10 хоногийн дотор тус улсаас гарах үүрэгтэй байдаг бол гаргах болсон тухай шийдвэрийг тухайн гадаадын иргэнд танилцуулан дахин оруулахгүй байх хугацааг заан, холбогдох зардлыг өөрөө хариуцахыг мэдэгддэг. Мөн албадан гаргах зардлыг гадаадын иргэнээс өөрөөс нь гаргах боломжгүй бол уригчаас гаргуулах, хэрэв төлбөрийн чадваргүй бол уг зардлыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргахаар ГИЭЗБТХ-ийн 37.6 дахь хэсэгт шийдвэрлэжээ.

⁷ Хилийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг. <http://www.montsame.mn/mn/read/41651> сүүлд үзсэн 2018.12.03.

Хүснэгт 1. Зөрчил шийдвэрлэсэн байдал⁸

Виз, бүртгэл. ГИЭЗБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.11, Дөрөвдүгээр бүлэгт, МУ-ын визийг хуудсаар олгох тухай заасан бол УИХ-ын 45 дугаар тогтоолоор баталсан “МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.4-т “... хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.”; “5.3.12-т Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна.”⁹ гэж тус тус заасан.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл¹⁰-ийн 1.1.3-т “Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжих, төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдийн хооронд цахим баримт бичиг солилцох, хувийн мэдээллийг дамжуулах, төрийн, байгууллагын, хувь хүний цахим өгөгдлийг хадгалах, хамгаалах, улс төрийн, цэрэг дайны болон хил дамнуулан арилжааны зорилгоор ашиглахаас сэргийлэх зэрэг асуудлыг хуулиар зохицуулах, банк санхүү, зам тээвэр, эрүүл мэнд, хөдөлгөөнт холбооны оператор, даатгал, үйлчилгээний байгууллагууд дээр цаасан болон цахим хэлбэрээр хадгалагддаг хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой өгөгдлийг хамгаалах тогтолцоог бий болгох” тухай зохицуулсан.

Олон улсын гэрээ, хэлцэлд мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглаж худалдаа, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх боломж, бололцоог гишүүн орнууддаа олгох зорилгоор Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенцийг НҮБ 2005 онд баталсан. Энэхүү конвенцид МУ нэгдэхээр¹¹ бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Бүртгэл. ГИЭЗБТХ-ийн 24.2-т “гадаадын иргэнийг урьсан МУ-ын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг бүртгүүлэх үүргийг хүлээнэ” гэж хуульчилсан бол бусад тохиолдолд Гадаадын иргэн өөрөө ГИХГ-т бүртгүүлэх үүрэгтэй¹² байна. Засгийн газар нь ГИЭЗБТХ-ийн 9.2.2, 9.2.3-д зааснаар гадаадын иргэн МУ-д оршин суух болон түүнийг бүртгэх, албадан гаргах болон дахин оруулахгүй байх хугацааг

⁸ Гадаадын иргэнийг албадан гаргасан буюу зөрчил шийдвэрлэсэн байдал нь 2017 оны эхний хагас жилтэй харьцуулахад 2018 онд өссөн үзүүлэлттэй байна. <http://immigration.gov.mn/files/hagas-jil-tailan-2018.pdf> сүүлд үзсэн 2018.12.10.

⁹ ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 45 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/advanced-search> сүүлд үзсэн 2018.12.07.

¹⁰ МУ-ын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, УИХ-ын 11 дүгээр тогтоол, <https://www.legalinfo.mn/advanced-search> сүүлд үзсэн 2018.12.07.

¹¹ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 3 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, <http://cita.gov.mn/wp-content/uploads/2018/10/3-last-1.pdf> сүүлд үзсэн 2018.12.17.

¹² ЗГ-ын 2018 оны 146 дугаар тогтоол “МУ-д оршин суух болон түүнийг бүртгэх журам”, <https://www.legalinfo.mn/advanced-search> сүүлд үзсэн 2018.12.07.

тогтоох журмыг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Энэхүү бүрэн эрхийн хүрээнд ЗГ-ын 2018 оны 146 дугаар тогтоол, 2010 оны 339 дүгээр тогтоолууд хэрэгждэг. Мөн ЗГ нь гадаадын иргэдийн /цагаач иргэд/ тоог УИХ-д өргөн мэдүүлснээр цагаач иргэдийн тоог УИХ-аас баталсан тогтоолын дагуу тогтоож, бүртгэл, баталгаажуулалтыг хийдэг.

ГИХГ-ын 2018 оны хагас жилийн ажлын тайланд¹³ мэдээлснээр “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 9,654 ширхгийг шинээр хэвлэн, 9889 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 197 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийж, цагаач, гэр бүлийн шалтгаанаар оршин суугч гадаадын 129 иргэнд хувийн хэрэг шинээр нээж, 663 иргэний хувийн хэрэгт баяжилт хийн нийт 1083 иргэний мэдээллийг цахим архивд оруулсан байна. Мөн гадаадын 55 иргэнд регистрийн дугаар олгож, харьяалалгүй 1 иргэнд зорчих үнэмлэх олгосон байна.

3.1.2. Хэрэгжиж байгаа сөрөг үр дагавар

Албадан гаргах. Зөрчлийн тухай хуулиар торгууль ногдуулах хариуцлага нь бүртгэлийн журам хоёр удаа зөрчсөн үндэслэлээр албадан гаргахад хүргэх юм.

ШИГТГЭЭ

Гадаадын иргэнийг бүртгэхтэй холбоотой, иргэн, аж ахуйн нэгж өнгөрсөн жилээс мөрдөгдөж ирсэн Зөрчлийн тухай хуулиар уригч иргэнийг 250 нэгж буюу 250 000 төгрөгөөр, байгууллага аж ахуйн нэгж бол 2500 нэгж буюу 2 500 000 төгрөгөөр торгоно” гэж тогтсон. Зөрчлөөс үүсэх үр дагаврыг бодвол бага учраас тодорхой хэмжээгээр багасгах, *100 нэгж буюу 100 000 төгрөгөөр, байгууллагыг 1000 нэгж буюу 1 000 000 төгрөгөөр* торгох гэж саналаа өгсөн боловч хууль батлагдах явцад 250 000 төгрөг, 2 500 000 төгрөг болсон. Ажлын 7 хоног гэж заасан нь хүндрэлтэй заалт. 30-аас дээш хоногоор байх тохиолдолд 30 хоног дотроо бүртгүүлэх нь зөв юм. МУ-д албан болон хувийн хэргээр оршин суух гэж байгаа хүн бол орж ирээд 30 хоногоос өмнө бүртгүүлэх, манай байгууллагын хувьд энэ нь бүртгэлийн шат дарааллын хамгийн сүүлийнх нь байдаг. ... шат дамжлага ихтэй, дээрээс нь бид хоногоор хааж өгч байгаа нь олон улсын жишигт нийцэхгүй байна. Одоо техник технологи сайжирсан. Цахим техник хэрэгслийг ашиглан бүртгэвэл уг асуудлыг шийдвэрлэх чухал алхам болно гэж үзэж байгаа.

*Гадаадын иргэн, харьяатын газрын
Эрх зүй, Гадаад харилцааны хэлтсийн
ахлах мэргэжилтэн Г. Ганбатын илтгэлээс¹⁴*

Өөрөөр хэлбэл, түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн, нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн тохиолдолд тухайн гадаадын иргэнийг албадан гаргах шаардлагатай болдог.

Гэтэл виз, бүртгэлийн асуудалд манай улсаас шалтгаалсан зөрчил дутагдал нэлээд байдаг. Тухайлбал, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлд “бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн” (ЗГ-ын 2018 оны 146 дугаар тогтоол буюу бүртгэлийн журмын 2.2-т гадаадын иргэн өөрөө бүртгүүлэх тухай заасан ч хэрхэн, яаж мэдээлэл авч бүртгүүлэх нь тодорхойгүй), “Гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасан хугацаанд зохих байгууллагад бүртгүүлээгүй бол...”, “визийн байх хугацааг хэтрүүлсэн бол гадаадын иргэн тус бүрээр зөрчилд тооцон хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” (өргөн уудам газар нутагтай хэдий ч зам, харилцаа холбоо хангалттай хөгжөөгүйгээс хугацаа хэтрэх тохиолдол гардаг) гэх мэтээр заасан нь зөрчлийг тодорхойлсон нэгдсэн ойлголттой болсон хэдий

¹³ ГИХГ-аас 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан цахим эх сурвалж: <http://www.immigration.gov.mn/blog/post/gadaadyn-irgen-haryaatyn-gazryn-hagas-zhilijn-tajlan> сүүлд үзсэн 2018.12.17.

¹⁴ ГИХГ “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг”, 2018.11.23.

ч эдгээр зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах бүтэц, тогтолцоо бүрдээгүй байна.

Энэ талаар Үндэсний аудитын газраас хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитаар “хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлээгүй нь хэрэгжүүлсэн ажлын үр нөлөөг бууруулж, гүйцэтгэлийг дүгнэх боломжгүй байна”¹⁵ гэснээс харж болох юм.

ШИГТГЭЭ

2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 950 гадаадын иргэнд ГИЭЗБТХ-ийн дагуу торгууль ногдуулж, 283 сая 328 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Тодруулбал, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн, визийн хугацаа хэтрүүлсэн, бусад зөрчил гаргасан иргэдийг албадан гаргасан. Манай улсад зорчиж буй гадаадын иргэд нь гэмт хэрэгт холбогдон хууль хяналтын байгууллагад шалгагдах тохиолдол багагүй байдаг. Энэ талаарх тоон мэдээлэл Цагдаагийн ерөнхий газраас сар бүр ирүүлдэг. Манай байгууллагад ирүүлсэн мэдээллээр 8 улсын 25 иргэн шүүхээр хорих ял шийтгүүлэн ялаа эдэлж байна.

*Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналтын улсын ахлах байцаагч
Н. Дуламсүрэнтэй хийсэн ярилцлаа*¹⁶

Үүнээс үзвэл сум, хорооны засаг дарга нь гадаадын иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллах үүрэг ГИЭЗБТХ-ийн дагуу хүлээдэг. Хэдийгээр ЦЕГ-аас гаргасан захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн тайланд нийт холбогдогч гадаад иргэдийн тоон үзүүлэлтийг тусгасан боловч, гадаад иргэдтэй холбогдсон гэмт хэрэг, захиргааны зөрчил тус бүр дээрх тоон үзүүлэлт, мэдээлэл, нийт улсад төлсөн торгуулийн хэмжээний үнийн дүн зэрэг нь уг тайланд тусгагдаагүй, орхигдсон байдаг тул цаашид бүртгэлийг иж бүрэн хийхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч байх талаар анхаарч ажиллах шаардлагатай нь харагдаж байна.

Виз, бүртгэл. ГИЭЗБТХ-ийн 33.2.13-д заасан зөрчлийн тэмдэглэлийн (бүртгэл) тухай хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа гэж үзэх үндэслэл нь хууль сахиулах эрх бүхий албан тушаалтан, байгууллага тус бүр гадаадын иргэнд холбогдох зөрчлийн тэмдэглэл хөтлөн явуулж байгаа явдал юм. МУ-ын нутаг дэвсгэрт гадаадын иргэний үйлдсэн захиргааны зөрчил /замын хөдөлгөөний дүрэм журам зөрчих г.м/ ГИХГ-т гадаадын иргэний хувийн мэдээллийн сан болон холбогдох байгууллагад тухайн зөрчил нэн даруй давхар бүртгэлээр бүртгэгдэх нь зүйтэй байна.

2017 оны 3 дугаар сард нийт 98 гадаадын иргэн захиргааны зөрчил гарган торгох ялаар шийтгүүлжээ¹⁷. Энэ нь гадаадын иргэний оршин суух үнэмлэхэд зөрчлийн тэмдэглэл хийх тухай зохицуулалтын хэрэгжилтэд сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй байна. Өөрөөр хэлбэл, МУ-д байх хугацаандаа гаргасан захиргааны зөрчил тус бүрийг ГИХГ нь гадаадын иргэний хувийн хэрэгт¹⁸ захиргааны болон

¹⁵ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан <http://forum.parliament.mn/projects/438> сүүлд үзсэн 2018.12.17.

¹⁶ Н.Дуламсүрэн: Манай улсад 13484 хятад иргэн ажиллаж, амьдарч байна. <http://medee.mn/mobile.php?eid=94698> сүүлд үзсэн 2018.11.26.

¹⁷ ЦЕГ-ын 2017 оны эхний 3 сард улсын хэмжээнд бүртгэгдсэн захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт https://police.gov.mn/resource/policegovmn/media/Statistic_medee/2017_03_sar_medee/2017.03_zahirgaanii_zurchil.pdf сүүлд үзсэн 2018.11.26.

¹⁸ Гадаадын иргэн, харьяатын газраас 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан. цахим эх сурвалж: <http://www.immigration.gov.mn/blog/post/gadaadyn-irgen-haryaatyn-gazryn->

бусад зөрчлийг ЦЕГ, хил хамгаалах газар болон холбогдох бусад байгууллагаас авч нэн даруй нэмэлт, өөрчлөлт, засвар хийх болон холбогдох мэдээллийн баяжилтыг хийх шаардлагатай болдог.

МУ-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулахаар УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.4-т тусгагдсан хэдий ч энэхүү зорилтыг хангахад манай улсын виз, бүртгэлийн асуудал хоцрогдсон, хууль тогтоомж, дүрэм, журам өөр хоорондоо нийцэхгүй давхардсан, зөрчилдсөн, хийдсэн төдийгүй, цаг үеэсээ хоцрогдсон уялдаа холбоо хангалтгүй байгаа нь сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал, гадаадын аялагч, жуулчид болон зорчигчдод сэтгэл зүйн хувьд дарамт, хүндрэл учруулах, дахин манай орныг зорих хүсэл эрмэлзэл буурах шалтгаан болдог тухай холбогдох хүмүүс дурдсан байна.

ШИГТГЭЭ

Монгол Улсын хүн амын гурван хувь, үүний дотор нэг улсын иргэн нэг хувь байж болдог, статистик тоон мэдээллээс харахад гадаадын иргэн оршин суух нь багасч байгаа. Гадаадын иргэд нь Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авахуулдаг. Захиргааны арга хэмжээ авхуулсан гадаадын иргэд дахин зорчиход хүндрэл үүсдэг. Гадаад иргэний хувьд хууль зөрчсөн мэдээлэл нь тухайн хүний мэдээллийн санд ордог. Энэ нь манай улсад дахин орж ирэхэд нэлээд асуудал үүснэ гэсэн үг.

*Гадаадын иргэн, харьяатын газрын Тамгын газрын дарга
М.Төрбаттай¹⁹ хийсэн ярилцлагаас*

Бүртгэл, тэмдэглэл хийх ажил нь ГИХГ болон ЦЕГ-ын мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлийн хүрээнд хараахан хийгдээгүйгээс²⁰ хөтлөн явуулах ажил хангалтгүй байна. Тухайлбал, гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагаанд саад учруулах, эсхүл гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргаж болзошгүй этгээдийг урьдчилан хууль сахиулах байгууллагын хяналт, бүртгэлд тэмдэглэн, анхаарал татсан этгээдийн тоонд зүй ёсоор тооцогдох шаардлагыг хангахад сөрөг үр дагавар үүсгэх эрсдэлтэй. Иймд МУ-ын хилээр нэвтрэн орж ирсэн гадаадын иргэн бүр өөрийн тусгай дугаартай²¹ байх, бүртгэлийн ажлыг нэгдсэн, хяналттай болгож, төрийн байгууллага хооронд мэдээлэл чөлөөтэй солилцох ажлыг эрчимжүүлэн, ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Бусад улсын туршлага. Гадаадын иргэдийн эрхийг хамгаалах асуудал нь бусад улс орны хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай уялдаж байх шаардлагатай байдаг. Тухайлбал, хилээр нэвтрэх орсон гадаадын иргэн шалган нэвтрүүлэх ажлаас тухайн улсын хөгжлийг эхлэн харах тул түр ирэгчийн виз, бүртгэлийн асуудал, үйлчилгээг сайжруулах, цаашлаад гадаадын иргэнийг албадан гаргах асуудлыг бусад үйл ажиллагаатай нягт уялдаа холбоотой байлгах, аюулгүй байдлыг хангах бодлогыг баримтлан ажиллах нь зүйтэй байдаг. Иймд бусад улс орны хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай уялдаж байх шаардлагатай тул энэхүү сэдвийн хүрээнд бусад улс орны талаарх холбоотой мэдээллийг товч оруулахыг зорилоо.

Албадан гаргах. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн²² 9 дүгээр хавсралтын III бүлгийн 5.18.1-д тохиролцогч улсууд болон агаарын

[hagas-zhiliin-tajlan](#) сүүлд үзсэн 2018.11.26.

¹⁹ Гадаадын иргэн, харьяатын газрын Тамгын газрын дарга М.Төрбаттай хийсэн ярилцлага <http://embassyofmongolia.co.uk/?p=2569&lang=mn> сүүлд үзсэн 2018.12.17.

²⁰ ГИХГ-ын ахлах мэргэжилтэн Г.Ганбаттай хийсэн ярилцлага. 2018.11.19.

²¹ ГИХГ нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг"-т тавьсан илтгэлээс, 2018.11.23.

²² Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенци. 1944 он. <https://www.legalinfo.mn/law/?cat=29> сүүлд үзсэн 2018.12.17.

тээвэрлэгчид нь боломжтой бол албадан гаргаж буй хүний талаар 24 цагийн турш холбогдож бүх сувгийг ажиллуулахыг зөвлөмж болгодог. Мөн тус конвенцийн 5.21-т заасны дагуу тохиролцогч талууд “нислэг эхлэх улсын эсхүл дамжин өнгөрөх улсын төрийн эрх бүхий албан байгууллагуудад тухайн хүний талаарх холбогдох мэдээллийг өгөх, тохиролцогч талууд албадан гаргаж буй хүний бичиг баримтын хамт агаарын тээвэрлэгчид хүлээлгэн өгөх”²³ үүрэг хүлээдэг. Иймд тухайн албадан гаргаж буй этгээдэд холбогдох конвенцийн 5.19 (а) албадан гаргах шийдвэрийн хуулбар, (б) харгалзагчтай бол түүний нэр, улсын харьяалал зэрэг нь зайлшгүй шаардлагатай байдаг. Олон улсын жишигт нийцүүлэх үүднээс тухайн улс нь өөртөө хувийн мэдээллийн бүрдүүлбэртэй байх нь урьдчилан сэргийлэх, ирээдүйд гарч болзошгүй аюулыг таслан зогсоох чухал ач холбогдолтой юм.

ХБНГУ, Шинэ Зеланд, Сингапур, БНХАУ зэрэг улсын жишээнээс хархад гадаадын иргэний эрх зүйн байдлыг зохицуулж буй суурь хууль тогтоомждоо зөрчил гаргасан гадаадын иргэнд сануулах, торгох, баривчлах, хууль бусаар олсон орлогыг хураах, албадан гаргах зэрэг хэд хэдэн төрлийн үндсэн арга хэмжээг авах тухай нийтлэг арга хэмжээ хэрэглэдэг байна.²⁴ Эдгээр арга хэмжээг зөвхөн зөрчил гаргасан гадаадын иргэнээс гадна түүнийг урьсан, батлан даасан, бүртгэсэн /жишээлбэл зочид буудал/, хувь хүн, албан байгууллага болон төрийн албан хаагчид мөн адил ногдуулдаг. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргасан гадаадын иргэн, гадаадын иргэний энэ үйлдлийг нуун дарагдуулсан, дэмжсэн, хамтарсан, мэдээлэх үүргээ биелүүлээгүй зэрэг үйлдэл гаргасан этгээдэд давхар арга хэмжээ авахаар зохицуулсан байна.

Энэ нь хүний наймаа болон хүнд худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гадаадын иргэн хохирогч болохоос хамгаалах нэг хэлбэр болдог байна. БНХАУ-ын гадаадын иргэн хуульд заасныг зөрчсөн нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдохгүй тохиолдолд Нийтийн аюулгүй байдлын албанаас хилээр албадан гаргана. Нийтийн аюулгүй байдлын албаны шийтгэлийн шийдвэр эцсийнх, албадан гарсан өдрөөс хойш 10 жилийн дотор Хятад Улсын хилээр орох эрхгүй. Хилээр нэвтэрсний дараа оршин суух зөвшөөрөл авах хүсэлтэй гадаадын иргэний виз дээр хил нэвтэрсний дараа оршин суух зөвшөөрлийг авах хугацааны талаар тэмдэглэл хийн 30 хоногийн дотор оршин суух газрын сумаас дээд шатны Ардын Засгийн газрын Нийтийн аюулгүй байдлын албанд хандах ёстой байдаг тухай судалгааны тайланд²⁵ дурдсан байна. /дэлгэрэнгүйг тайлангаас үзнэ үү./

АНУ-ын хувьд Цагаачлал болон Гаалийн Алба /ICE/²⁶ албадан гаргах ажиллагааг эрхлэх ажлын хүрээнд гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг юм. Олон нийтийн аюулгүй байдал, үндэстний аюулгүй байдалд аюул учруулах, эсхүл олон нийтийн амар тайван байдлыг эрсдэлд оруулах болон АНУ-ын хилээр хууль бусаар нэвтрэн орж ирсэн, тус улсын Цагаачлалын хууль тогтоомж, хилийн халдашгүй дархан байдлыг үл ойшоосон гадаадын иргэн, бичиг баримтгүй этгээдийг илрүүлэх, гүйцэтгэх ажиллагаа, тус улсаас гаргах арга хэмжээ авах нь тус албаны эрхэм зорилго болно. Цагаачлал болон Гаалийн Алба нь ихэвчлэн аюултай, онц аюултай гэмт хэрэгтэн, хүн амины гэмт хэрэг, бэлгийн мөлжигчид, хар тамхи тээвэрлэсэн, гадаадын иргэний хууль бус наймаа, манай нийгэмд сөрөг үр нөлөө үзүүлэх бусад гэмт хэрэг үйлдэхэд оролцсон байх этгээдүүдийг олж илрүүлэн тус улсаас гаргах зорилготой.

²³ ГИХГ, Мэдээлэл 2018/1 Уб., 2018 он.

²⁴ Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын зарим зохицуулалт, харьцуулсан судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Уб., 2015 он. 96 дахь тал. <http://nli.gov.mn/?cat=19&paged=5> сүүлд үзсэн 2018.12.17.

²⁵ Мөн тэнд.

²⁶ U.S. Immigration and Customs Enforcement <https://www.ice.gov/enforcement> сүүлд үзсэн 2018.11.28.

Барак Обама АНУ-ын ерөнхийлөгч болсон эхний гурван жилд буюу 2010 оны байдлаар жилд 300000 хүнийг албадан гаргасан нь хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож байсан бол 2017 онд энэ үзүүлэлт даруй хоёр дахин нэмэгдсэн байна.²⁷

АНУ-д Цагаачлалын болон харьяатын тухай /INA 1952/, Дотоодын аюулгүй байдлын тухай /2002/, Цагаачлалын шинэчлэл болон хяналтын тухай, Цагаачлалын зорилгоор хуурамчаар гэрлэхийн үр дагаврын тухай, Хууль бус цагаачлалд шинэчлэл хийх болон цагаачдын хариуцлагын тухай, Хүүхдийн иргэний харьяаллын тухай, Улс хоорондын үрчлэлийн тухай, Хууль ёсны цагаачлал болон гэр бүлийн тэгш эрхийн тухай, Хүүхдийн эрх зүйн байдлыг хамгаалах тухай, Эх оронч үзлийн тухай, Хувийн нууцын тухай, Хилийн өндөржүүлсэн аюулгүй байдал болон орох визийн шинэчлэлийн тухай хуулиуд үйлчилдэг. 1929 оны хуулиар анх цагаачлалын асуудлаа чангатган, цагаачлалын байгууллага тухайн гадаадын хүн АНУ-д байх хангалттай нотолгоо гаргаж чадаагүй гэж үзсэн тохиолдолд түүнийг депортац хийж /албадан гаргах/ болно гэж заасан юм. Сүүлийн үед визийн статус зөрчсөний хариуцлагыг чангатган АНУ-аас албадан гаргагдсан хүнийг 10 жилийн хугацаагаар АНУ-д оруулахгүй байх хоригийг хэрэглэдэг болсон. Байнга оршин суух статусынхаа нөхцөлийг зөрчсөн, эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн, хуурамч бичиг баримт үйлдсэн, оршин суух хаягаа бүртгүүлээгүй, үндэсний аюулгүй байдлыг зөрчсөн, нийгэмд дарамт учруулах зэрэг шалтгаанаар гадаадын иргэнийг албадан гаргах хүртэл арга хэмжээ авдаг байна.²⁸

Виз, бүртгэл Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн²⁹ 9 дүгээр хавсралтын III бүлгийн 3.23-т “тохиролцогч улсууд нь өөрийн улсын хуулийн дагуу байнга оршин сууж байгаа гадаадын иргэнийг гарах-орох виз авахыг шаардахгүй”, 3.25-д “виз олгох үйл ажиллагааны үед визийн мэдүүлэг гаргасан этгээдийг өөрийн биеэр виз олгох газарт ирэхийг шаардахгүй”, мөн 3.26-д тус “тохиролцогч улсууд нь визийг олгосон өдрөөс эхлэн визийн төрөл, байх хугацаанаас үл хамааран доод тал нь 6 сарын хүчинтэй хугацаагаар олгох хэрэгтэй” хэмээн зөвлөмжилдөг.

Визийн ангилал нь улс орон бүрд харьцангуй өөр зохицуулагдсан байх боловч нийтлэг зорилго болох жуулчлах /зочлох/, хөрөнгө оруулалтын /бизнесийн/, дамжин өнгөрөх, суралцах гэсэн үндсэн 4 зорилгын хүрээнд олгох виз давамгайлах ба эдгээр нь олон ангилал, дэд ангиллуудаас бүрддэг байна. Ийнхүү ангилж байгаа явдал нь визийн хүрээнд эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон тавигдах шаардлагыг улам нарийвчлан зохицуулах боломжийг олгодог байна. Визийн ангиллыг тухайн визийн зорилгыг илэрхийлсэн үгийн эхний үсгээр /Хятад/, тоон кодоор /Австрали/ эсхүл үсгийн дарааллаар /Шенген/ тэмдэглэдэг. Мөн виз олгох онцгой нөхцөлийн нэг бол боомт дээр виз олгох бөгөөд бусад улсын туршлагаас хархад дамжин өнгөрөх, түр хугацааны виз байх ба тухайн улсын хилээр нэвтрэх буй иргэний зорчих зорилгын хувьд янз бүр байж болох хэдий ч энэ зорилго нь ихэвчлэн визийн хугацаагаар хязгаарлагдан онцгой тохиолдолд байдаг төдийгүй яаралтай, нотолж чадсан, богино хугацаатай, зорчих нутаг дэвсгэр заасан зөвшөөрөл, виз олгох эрх бүхий албан байгууллага, албан тушаалтан бичиг баримтаа бүрэн бүрдүүлсэн тохиолдолд олгодог байна.

Сингапур Улсад зорчихыг хүсэгч гадаадын иргэн нэвтрэхийн тулд Цагаачлал шалган нэвтрүүлэх газарт цахимаар виз мэдүүлдэг. Хэрэв нэвтрэхийг зөвшөөрвөл хилээр орох үед нь 30-90 хоногийн хугацаатай түр зорчих тасалбар олгодог.

²⁷ Migration Policy Institute, REVIVING UP THE DEPORTATION. MACHINERY. Enforcement and Pushback under Trump. Report in Brief. By Randy Capps..., May, 2018. P.7

²⁸ Г.Сэсээр. АНУ-ын цагаачлалын эрх зүйн зарим асуудал, Вашингтон хот 2006 он, 80, 20, 107, 273 дахь тал.

²⁹ ГИХГ, Мэдээлэл 2018/1 УБ., 2018 он, 11 дэх тал.

Ажлын тасалбар авахаар цахимаар мэдүүлсэн бол ажлын 7 хоногт харин биечлэн материал хүргэх замаар мэдүүлбэл 5 долоо хоногт шийдвэрлэдэг.

Хонконг Улсын хувьд Англи Улсын иргэд 180 хүртэл хоногоор визгүй мөн Хонконгт оршин суух болон байнгын оршин суух үнэмлэхтэй гадаадын иргэд визгүй зорчдог байна.³⁰

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах тухай” зорилт дэвшүүлсэн. Үүнтэй холбогдуулан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх талаар зохицуулсан. Харин хуулийн төслийг хариуцсан холбогдох мэргэжилтэн “зөвхөн онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах” талаар судлах нь хангалтгүй гэж үзсэн тул ГИХГ-ын саналыг бүхэлд нь тусгахыг зорьсон. Мөн үнэлгээний хүрээг өргөжүүлэн албадан гаргах, виз, бүртгэлийн журам зөрчсөнтэй холбоотой зохицуулалт болон бусад улсын талаар цухас дурдсан.

Манай улсыг зорих, айлчлал хийх, ажиллаж, амьдрах гадаадын иргэдийн тав тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж, бусад улсын жишгээр виз, бүртгэлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг нийцүүлэн батлан гаргах нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хангах чухал алхам юм. Ийнхүү гол харилцааг зохицуулж буй хуулиас гадна ЗГ-ын 2010 оны албадан гаргах, виз, бүртгэлийн журмыг 2018 онд шинэчилсэн. Гэвч хуулиар зохицуулж буй зарим асуудлыг өөрчлөх шаардлага бий болоод байна. Тухайлбал, нэвтрэх зөвшөөрлийг хуудсаар олгох тухай зохицуулалт үйлчилж байгаа, оршин суух зөвшөөрөлтэй болон бусад улсын жишгээр орох, гарах визийг карт болгоогүй, зэрэг олон улсын жишиг хийгээд практикт нийцүүлэх, мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн зарим зохицуулалтыг өөрчлөн найруулахаар байгаа юм.

Дээрх хууль, тогтоомжоор хүлээлгэх хариуцлага, зөрчил дутагдлыг засаж сайжруулахгүйгээр “Түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээх” болон нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн тохиолдолд албадан гаргах шаардлагатай болж байна.

Ийнхүү гадаадын иргэдийн гэмт хэрэг зөрчилд холбогдсон, урьд холбогдож байсан, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн талаарх мэдээлэл дутмаг байдаг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шатанд нэгдсэн бүтэц, тогтолцоо бүрдээгүй, хууль тогтоомжийн болон байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй, цахим орчин бүрдээгүй ч гэсэн хоёр удаагийн зөрчил гаргасан гадаадын иргэнийг бүртгэн тэмдэглэл үйлдэн албадан гаргаж байгаа явдал нь аялагч, жуулчдын тоог бууруулж байх тул зөрчилд тооцох шалтгаан (баривчлах, торгох, хууль бусаар олсон орлогыг хураах, албадан гаргах) тус бүрд оногдох үндэслэлийг тодорхой болгох, шаардлагатай байна.

МУ-д орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух болон албадан гаргах зэрэг бүхий л асуудлыг цахимжуулан визийн асуудлыг шийдвэрлэн хууль тогтоомжийн уялдаа холбоог ханган, зөрчил, давхардал, хийдлийг арилгаснаар төрийн байгууллагын ажил хөнгөрөх төдийгүй гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээлэл, орсон гарсан гадаадын иргэний мэдээлэл, бүртгэл бүрэн утгаараа хөгжих, түүнийг

³⁰ Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын зарим зохицуулалт, харьцуулсан судалгаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2015 он. 100 дахь тал.

хэрэгжүүлэгч байгууллага хоорондын уялдаа холбоо сайжран гадаадын иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээлийг бууруулах ач холбогдолтой.

Ийнхүү судалгааны үр дүнгээс дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- ГИЭЗБТХ-ийн 37 дугаар зүйлд заасан гадаадын иргэнийг албадан гаргах асуудал нь МУ-д айлчлан ирж буй аялагч, зочид, төлөөлөгчдөд илүү хамаарах ба 37.1.3 дахь заалтад “түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн” тухай зохицуулалтын хэрэгжилт нь хууль тогтоомжийн уялдаа холбоо, бусад шалтгаанаар зөрчигдөх явдал ихсэж байх тул зөрчилд тооцох шалтгаан (торгох, хууль бусаар олсон орлогыг хураах, баривчлах, албадан гаргах) тус бүрд оногдох үндэслэлийг тодорхой болгох, зөрчлийн тоо бүртгэл, статистик мэдээлэл боловсруулалт, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судлах, дүн шинжилгээ хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах бүтэц, тогтолцоо, цахим орчинг бүрдүүлэх;

- ГИЭЗБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.11 дэх хэсэгт заасны дагуу “МУ-ын виз” гэж “... нэвтрэн орох эрх олгосон зөвшөөрлийн хуудсыг” гэснийг “цахим хэлбэрээр олгосон зөвшөөрлийг” гэж өөрчлөн найруулах;

- ГИЭЗБТХ-ийн 11.5 дахь хэсэгт “виз нь орох, гарах-орох ...нэг, хоёр олон удаагийн төрөлтэй байна” гэж заасан “оршин суух карттай бол” гарах орох виз авахыг шаардахгүй байх буюу 180 хоногоос дээш хугацаагаар олгосон оршин суух үнэмлэхтэй бол гарах орох виз шаардахгүй байхаар зохицуулалт нэмэх;

ЭХ СУРВАЛЖ

Нэг. Олон улсын гэрээ

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он.
2. Олон улсын иргэний нисэхийн тухай тухай Чикагогийн Конвенци. 1944 он.
3. Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенци 1965 он.

Хоёр. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль, ТМЭ, 1992 он, №1
2. Аялал жуулчлалын тухай, ТМЭ 2000 он, №19
3. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2010 он, №32
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай, ТМЭ 2017 он, №24
5. Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2017 он, №24
6. Иргэний улсын бүртгэлийн тухай /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2018 он, №28
7. Иргэний хууль, ТМЭ 2002 он, №7
8. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, ТМЭ 1994 он, №2
9. Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2018 он, №28
10. Үндэсний аюулгүй байдлын тухай, ТМЭ 2002 он, №3
11. Харьяатын тухай, ТМЭ 1995 он, №10-11
12. Монгол Улсын хилийн тухай хууль, ТМЭ 2016 он, №6
13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2011 он, №40
14. Хөдөлмөрийн тухай, ТМЭ 1999 он, №25

15. Хөрөнгө оруулалтын тухай, ТМЭ 2013 он, №41
16. Хүн худалдаалахтай тэмцэх тухай, ТМЭ 2012 он, №7
17. Эрүүгийн хууль, ТМЭ 2002 он, №5
18. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2016 он, №7
19. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /Шинэчилсэн найруулга/, ТМЭ 2017 он, №23

Гурав. Уйх-ын тогтоол

1. байдлын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/, УИХ-ын 10 дугаар тогтоол, 2010 он.

Дөрөв. ЗГ-ын тогтоол

1. Журам шинэчлэн батлах тухай /МУ-ын виз олгох журам/, ЗГ-ын 145 дугаар тогтоол, 2018 он.
2. Гадаадын иргэн МУ-д оршин суух болон түүнийг бүртгэх журам, ЗГ-ын 146 дугаар тогтоол, 2018 он.
3. Журам шинэчлэн батлах тухай /Гадаадын иргэнийг МУ-аас албадан гаргах болон МУ-д дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам/, ЗГ-ын 147 дугаар тогтоол, 2018 он.
4. Журам батлах тухай, Гадаадын иргэнийг МУ-аас албадан гаргах болон МУ-д дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам, ЗГ-ын 339 дүгээр тогтоол, 2010 он.
5. МУ-ын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам, Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоол.
6. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай / Гадаадын иргэн МУ-д оршин суух болон түүнийг бүртгэх журам/, ЗГ-ын 219 дүгээр тогтоол, 2015 он.
7. Жагсаалт батлах тухай/ МУ-д визгүй зорчих гадаад улсын жагсаалт/, ЗГ-ын 186 дугаар тогтоол, 2014 он.
8. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай, ЗГ-ын 101 дүгээр тогтоол, 2014 он.
9. МУ-д суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам, ЗГ-ын 97 дугаар тогтоол, 2012 он.
10. Хилийн боомтын жагсаалт батлах тухай, ЗГ-ын 4 дүгээр тогтоол, 2011 он.
11. Боомтуудын ерөнхий төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт батлах тухай, ЗГ-ын 102 дугаар тогтоол, 2010 он.
12. Журам батлах тухай, Алтанбулаг хилийн чөлөөт бүс, ЗГ-ын 43 дугаар тогтоол, 2009 он.
13. Олон улсын нислэгийн талаар авах арга хэмжээний тухай, ЗГ-ын 69 дүгээр тогтоол, 2007 он.
14. Журам батлах тухай, МУ-ын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам, ЗГ-ын 62 дугаар тогтоол, 2003 он.
15. Журамд нэмэлт оруулах тухай /Хилийн мэргэжлийн хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай/, ЗГ-ын 238 дугаар тогтоол, захирамж. 2001 он.
16. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай, ЗГ-ын 71 дүгээр тогтоол, 2001 он.

Тав. Сайдын тушаал

1. Хууль зүй дотоод хэргийн сайд, Санхүү эдийн засгийн сайдын хамтарсан тушаал, дугаар 142/124, 2002 оны 5 дугаар сарын 31-ний өдөр, /Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны тухай/

2. Гадаад харилцааны сайд, Хууль зүйн сайд, Батлан хамгаалахын сайд, Улсын аюулгүй байдлыг хангах газрын даргын тушаал, дугаар 153/107/192/193, 1997 оны 5 дугаар сарын 16-ны өдөр, /МУ-ын виз олгох журам/

3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын тушаал, дугаар А/429, 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, /Гадаадын иргэнд МУ-д хувийн хэргээр зорчих урилга олгох журам/

4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаал, дугаар 100/32, 2001 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр, /Гадаадын иргэнд МУ-ын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам/

5. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, дугаар А/187, 2018 оны 10 дугаар сарын 01-ны өдөр, /Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд оршин суух, харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, тэдгээрийг эзэмших, хадгалах, ашиглах журам”, “Оршин суух үнэмлэхийн загвар”, “Зорчих үнэмлэхийн загвар”/

6. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан тушаал, дугаар 112/339, 2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр, /Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журам/

Зургаа. Засгийн газрын агентлагийн даргын тушаал

1. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын тушаал, дугаар А/226, 2014 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр, /МУ-ын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалт/, /МУ-ын харьяат болох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загвар/, /МУ-ын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загвар/, /МУ-ын харьяатаас гарах хүсэлт гаргагчийн мэдүүлгийн хуудасны загвар/

2. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын тушаал, дугаар А/284, 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдөр, /Гадаадын иргэнд МУ-д хувийн хэргээр зорчих урилга олгох журам/, /МУ-д хувийн хэргээр зорчих урилгын загвар/

3. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, дугаар А/111, 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдөр, /Гадаадын иргэнийг МУ-аас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам/

4. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын тушаал, дугаар А/396, 2010 оны 12 дугаар сарын 8-ны өдөр, /МУ-ын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх тухай журам/

Долоо. Ном, гарын авлага эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

1. Гадаадын иргэний шилжилт хөдөлгөөний чиг хандлага, анхаарах асуудал / олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл/, Уб., 2017 он.

2. Гадаадын Иргэн Харьяатын Газар, Мэдээлэл, 2018/1 Уб., 2018 он.

3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны тогтолцоо. Уб., 2008 он.

4. “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл, №2, “Иргэний давхар харьяаллын өнөөгийн нөхцөл байдал ба олон улсын туршлага”. Уб., 2017 он.

5. “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүл, №2, Иргэний харьяалал ба улс орнуудын хууль тогтоомжийн харцуулалт, Уб., 2005 он.

6. Хууль дээдлэх ёс, №1, Гадаадын иргэний эрх зүйн байдлын зарим зохицуулалт-харьцуулсан судалгаа. Уб., 2016 он,

7. О.Өнөрцэцэг. Олон улсын эрх зүй, Уб., 2003 он.
8. Д.Цолмон. АНУ-ын гадаад бодлогын түүх, дипломат ажиллагаа, Уб., 2005 он.
9. Г.Сэсээр. АНУ-ын цагаачлалын эрх зүйн зарим асуудал, Вашингтон хот, 2006 он.
10. Д.Ундралсайхан. Орчин үеийн олон улсын эрх зүй, Уб., 2016 он.
11. Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн процессын эрх зүй, Уб., 2011 он.
12. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл Уб., 2017 он.
13. Эрх зүй” эрдэм шинжилгээний өгүүлэл №1, Д.Булган, “Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх, түүний оршин байгаа газрыг ашиглуулахтай холбоотой МУ-ын Үндсэн хуулийн үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал”. Уб., 2017 он.
14. Pangle, T. L., & Ahrendorf, P. J. 1999. Justice among nations
15. The Greenwood encyclopedia of international relations, Cathal J. Nolan. Vol II. Westport, Greenwood Pub., 2002.

Найм. Цахим эх сурвалж

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг, <http://www.immigration.gov.mn/blog/post/gadaadyn-irgenij-erh-zjn-bajdyn-tuhaj-huuld-nemelt-rchllt-oruulah-tuhaj-neelttej-helelclee>
2. Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаадын иргэн, харьяатын газар хамтран “Гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөний чиг хандлага, анхаарах асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөнгийн тавьсан илтгэлээс, <https://ikon.mn/n/156a> <http://embassyofmongolia.co.uk/?p=2569&lang=mn>
3. Гадаадын иргэн, харьяатын газраас 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, <http://www.immigration.gov.mn/blog/post/gadaadyn-irgen-haryaatyn-gazryn-hagas-zhiliin-tajlan>
4. ЦЕГ, 2017 оны эхний 3 дугаар сард улсын хэмжээнд бүртгэгдсэн захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт, https://police.gov.mn/resource/policegovmn/media/Statistic_medee/2017_03_sar_medee/2017.03_Gemt_hereg_uildegsed.pdf
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, <http://forum.parliament.mn/projects/438>
6. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 3 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, <http://cita.gov.mn/wp-content/uploads/2018/10/3-last-1.pdf>
7. ILO, Trade Unions and Migrant Workers New Contexts and Challenges in Europe https://www.ilo.org/global/publications/books/WCMS_591484/lang--en/index.htm
8. U.S. Immigration and Customs Enforcement <https://www.ice.gov/>

---o0o---